

**ЖАКЛИН ТЕВЕНЕ-ГИЙН  
«МОНГОЛЧУУД ЧИНГИС  
ХААНААС ӨНӨӨ ҮЕ ХҮРТЭЛ»  
НОМЫН ТУХАЙ**

Jacqeline Thevenet: Les Mongols de  
Chingis khan de L' aujourd'hui, P. 1986. p, 223

Францын Арман Колэн хэвлэлийн газраас эрхлэн 1986 онд Париж-д хэвлэсэн энэ номонд зохиогч дундад зууны үеэс одоо хүртэлх Монгол орны улс төр, нийгэм-эдийн засаг, оюун санааны амьдралыг бодит байдлаар сурталчилгааны хэлбэрээр дүрсэлжээ. Ном өмнөх үг, 3 бүлэг, төгсгөлөөс бүрджээ.

Өмнөх үгийг Францын монгол судлаач Р. Амайон бичсэн бөгөөд уг номонд Монголын тухай товч тодорхой баримт сайтай өгүүлсэн гэж тэмдэглэсэн нь үнэн байдалд нийцэж байна.

«Монголчууд, Монгол орон» гэсэн эхний хэсэгт монголчуудын үндэс угсаа, угсаатны шинж чанар, монголчуудын байршлын тухай болон БНМАУ-ын физик газар зүй, байгаль, цаг уур, ургамал, амьтны аймгийн талаар товч мэдээлжээ.

«Монголчуудын түүх» гэсэн номын нэгдүгээр бүлэгт монгол овог аймгууд үүсэж хөгжсөн, улмаар Чингис хаан тэднийг нэгтгэсэн, түүний байлдан дагуулалт, Чингисийг залгамжлагчдын тухай, Манжийн дарлалын үеийн Монгол орон, автономитын үе, монгол ардын хувьсгалын ялалтаас одоо хүртэлх үеийг тус тус товч өгүүлжээ.

Манай эриний өмнөх III зууны үед Монголын нутаг дэвсгэрт Хүннү нараас эхлээд олон зуун жилийн турш нүүдэлчин овог аймгууд амьдарч байсныг өгүүлээд 13-р зууны үед Чингис хаан нүүдэлчин олон аймгуудыг нэгтгэж Монголын төр улсыг байгуулсныг тэмдэглэжээ.

Номонд Чингис хааныг залгамжлагчдын тухай, тэдгээрийн байлдан дагуулалтын талаар он цагийн дэс дарааллаар, эзэлсэн гзар нутгийг товч товчих хэлбэрээр өгүүлжээ. Түүнчлэн зургаар дүрсэлжээ.

«Автономитын үе ба тусгаар тогтнол, 1911—1924» гарчигтай дараагийн зүйлд 1911 оны Монголын нийгмийн тухай өгүүлжээ. Зохиогч Монголын нийгэм феодал, ард ангиас бүрдэж байсныг тэмдэглээд феодалууд бүх бэлчээр нутаг, малын тэн хагасыг эзэмшиж байхад ард анги нийт малын 30-ийг эзэмшиж байсныг цохон тэмдэглэжээ. Түүнчлэн эрэгтэйчүүдийн дийлэнх хэсэг олон зуун сүм хийдэд шавилан сууж, нийгэм—эдийн засгийн амьдралаас тасархай байсан зэрэг нь улс орны хөгжил дэвшилд муугаар нөлөөлж байсныг зохиогч зүйтэй тэмдэглэжээ.

Монголын ард түмэн гадаад дотоодын давхар дарлал мөлжлөгөд талхигдан зовж байсныг Ж. Тевенэ цохон тэмдэглэж байгаа нь чухал ач холбогдолтой юм. Тэрээр Япон, Хаант Орос, Өрнөдийн зарим орон Монголыг тонон дээрэмдэж байсныг бас дурджээ. Зохиогч ийнхүү XX зууны эхэн үеийн Монголын нийгмийн ангийн бүтэц, зөрчлийг цухас боловч дурдаж байгаа нь гадаадын уншигчдад Монголын ард түмний үндэсний чөлөөлөх хөдөлгөөн, ардын хувьсгалын объектив нөхцөл шалт гааныг зөв ойлгоход тус дөхөм болох юм. Харин тусгаар тогтнолоо сэргээж Богд хаант Монгол улсыг зарласан түүхийг буюу зохиогчийн нэрлэж буйгаар автономитыг тогтоосон явдлыг зохиогч гагцхүү 1911 оны Хятадын хувьсгалын хүрээнд авч, Монголын ард түмний улс үндсээ чө-

лөөлөх тэмцэл, Орос оронд өрнөсөн хувьсгалт хөдөлгөөнтэй холбож үзээгүй нь Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн гадаад дотоод хүчин зүйл, үндэс шалтгааныг бүрхэгдүүлсэн тал байна.

Хятадын цэргийн эрхтнүүд автономитыг устгасан тухай, улмаар нийслэл хүрээнд хувьсгалт бүлгэмүүд байгуулагдсан, 1921 оны Монгол ардын хувьсгал ялсан зэрэг түүхэн үйл явцыг товч тодорхой, он цагийн дэс дарааллаар, улс төрийн тайлбар багатай бичжээ.

БНМАУ-ын талаар хөрөнгөтний ихэнх зохиогчдын ном зохиолоос ялгаатай нь энэ номонд зохиогч «Монгол орон феодализмаас социализмд дэвшин хөгжсөн» гэж тэмдэглэж байна. Ж. Тевенэ БНМАУ-ын түүхэн хөгжлийн үечлэлийг 1. Ардчилсан шат (1921—1940) 2. Социалист шат (1940—1960) 3. Социализмыг байгуулж дуусгах шат гэж хуваажээ. (номын 77-р тал) Энэ үечлэлийг хийхдээ БНМАУ-д гадаад хэл дээр хэвлэгдсэн судалгааны материалыг баримталсан нь бас тэмдэглүүштэй.

Гэвч Ж. Тевенэ манай орны хөгжлийн үе шатууд, тэдгээрийн онцлогийг хөрөнгөтний «шинэчлэлийн» онолын үүднээс тайлбарлажээ. Тэрээр манай орны хөгжил дэвшилд МАХН-ын гүйцэтгэсэн ба гүйцэтгэж буй түүхэн ролийг зориудаар мушгин гуйвуулдаг хөрөнгөтний ихэнх түүхчдийн мугуйд аргыг давтаагүй боловч МАХН-ын үйл ажиллагааны зар чим, үүрэг ролийн талаар дурдахдаа тэр нь «Зөвлөлт Холбоот Улсынх тай нэгэн адил улс орны нийгэм улс төрийн хүчнүүдийг бүрэн хяналтандаа оруулсан» гэж (номын 77-р тал) аливаа социалист ор нуудын Коммунист ба ажилчны намуудын нэгэн адил улс төрийн талаар удирдан чиглүүлэгч МАХН-ын ролийг улс орны бүхий л амьдралыг дарангуйлан захирч төр, захиргаа, аж ахуй, олон түмний байгууллагыг орлоход оршдог мэтээр ухдаг өрөөсгөл хандлагаас салж чадаагүй нь харагдаж байна. Зохиогч Монгол-Зөвлөлтийн ард түмний найрамдал, хамтын ажиллагааны түүхэн замналыг нэлээд бодит байдлаар бичихийг оролдсон боловч уг холбоо найрамдлын мөн чанар, олон улсын харилцааны шинэ маяг болохыг хүлээгээгүй учир Монголыг ЗХУ бүр 20-иод оны эхээр «өөрийн хүрээнд татан оруулсан» гэдэг нэр томъёо хэрэглэхэд хүргэжээ. Харин Капиталист биш хөгжлийн тухай В. И. Лениний үзэл санаа Монголд хийгдсэн өөрчлөн байгуулалтын гол агуулга, гол уриа болсон бөгөөд бусад улс оронтой харьцуулахад тус орны онцлог болсон гэдгийг зөвшөөрөн хүлээжээ. Социалист байгуулалтын орчин үеийн шатанд ЗХУ-ын тусламжтайгаар БНМАУ-д аж үйлдвэрийн салбар хөгжиж байгааг зохиогч Дархан, Эрдэнэт, Бага нуурын цогцол борын жишээн дээр дурджээ.

«Өдөр тутмын амьдрал» гэсэн гарчигтай номын хоёрдугаар бүлэгт Монголчуудын мал малладаг заншил, ан агнадаг арга ажиллагаа, ангийн төрөл, монгол гэр барих, аж төрөх заншил, хооллодог заншил, цагаан идээ бэлтгэдэг зарим арга, Монгол дээл, гоёл чимэглэл, баяр ёслол, эрийн гурван наадмыг орчин үеийн монголчуудын зан заншил, аж төрөх ёсны зарим элементийн хамт багтаасан нь уншигчдад сонирхолтой болжээ.

«Соёлын өв» гэсэн номын гуравдугаар бүлэгт шашин шүтлэг, шарын цацны тухай, гэр бүлийн харилцааны, зан заншил, тухайлбал хүүхдэд нэр өгөх, хүүхдийн даахь авах, гэрлэх ёс, хурим хийх ёс заншил, түүнчлэн монгол хэл уран зохиол, хөгжим урлагийн тухай өгүүлжээ.

Бүхэлдээ Ж. Тевенэгийн энэ ном хөрөнгөтөн орны уншигчдын манай орны түүх, соёл, өнөөгийн хөгжилтийн талаархи мэдлэгт бүрэн биш боловч нэлээд материал өгч чадахуйц бүтээл болжээ.

**Л. Оюунгэрэл**  
түүхийн ухааны дэд эрдэмтэн